

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
10 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг

	<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
	<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 5
	<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6 – 32
1.	<i>Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</i>	6 – 11
2.	<i>Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/</i>	11 - 32

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 02-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 77 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Б.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, Ж.Золжаргал, Л.Мөнхбаясгалан, Б.Мөнхсоёл, П.Мөнхтулга, Д.Пүрэвдаваа, Р.Сэддорж, Ч.Ундрал, Д.Үүрийнтуяа, Г.Хосбаяр;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Б.Дэлгэрсайхан, Ж.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Ж.Баясгалан, Л.Гантөмөр, С.Лүндэг;

Тасалсан: Н.Алтаншагай, Д.Батбаяр, Б.Жавхлан, Д.Жаргалсайхан, Ч.Лодойсамбуу, Н.Учрал, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;

Хоцорсон: Д.Батлут – 01 минут, Х.Баттулга – 10 минут, Б.Батцэцэг – 30 минут, Ж.Бат-Эрдэнэ – 01 минут, Х.Болормаа – 08 минут, Э.Болормаа – 46 минут, Д.Ганбат – 30 минут, Ц.Даваасүрэн – 22 минут, Т.Доржханд – 57 минут, Б.Жаргалан – 30 минут, Б.Заяабал – 01 минут, Ц.Мөнхбат – 29 минут, Ц.Мөнхтуяа – 06 минут, Н.Наранбаатар – 1 цаг 01 минут, П.Наранбаяр – 04 минут, М.Нарантуяа-Нара – 05 минут, О.Номинчимэг – 04 минут, Б.Пунсалмаа – 03 минут, Ц.Сандаг-Очир – 02 минут, Б.Тулга – 43 минут, Ж.Чинбүрэн – 01 минут, Ө.Шижир – 03 минут, Р.Эрдэнэбүрэн – 36 минут.

Нэг.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан авсан завсарлага дууссаныг мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүд чуулганы нэгдсэн хуралдаанд оролцохгүй гэдгийг мэдэгдэж, Ардчилсан намын бүлгийн гишүүд хуралдааныг орхин гарав. /10:10/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг санал хураалтаар үргэлжлүүлэн хэлэлцэв.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСӨЛ

Х.Булгантуяа: 1.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 40

Бүгд: 88

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Байнгын хорооны саналаар Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 41

Бүгд: 88

53.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Байнгын хорооны саналаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 40

Бүгд: 88

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 9 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын дэд дарга Х.Булгантуяа “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /10:18/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хуулийн мэргэжилтэн Б.Алтанцэцэг, Хүнсний аюулгүй байдлын шинжээч, доктор (Sc.D) Д.Энхмаа, зөвлөх инженер, доктор (Ph.D), дэд профессор Ж.Туяацэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан авсан завсарлага дууссан талаар, мөн 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн албан бичгээр Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулах гэсэн саналаа татан авч байгаа талаар мэдэгдэв.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Ганмаа, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Хүнсний аюулгүй байдлын шинжээч Д.Энхмаа, зөвлөх инженер Ж.Туяацэцэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Нарантуяа-Нара, Д.Ганмаа нар үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав. /11:05/

Уг асуудлыг 11 цаг 05 минутад хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 98 гишүүн ирж, 77.8 хувийн ирцтэйгээр 11 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 00 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Өнөөдрийн ирц 58.7 хувьтай байна.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн хуралдааны чуулганыг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах хоёр асуудлыг хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хоёрдугаарт, Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Үг байхгүй. Дэгийн тухай хуулийн дагуу үг байхгүй.

Хэлэлцэх нэгдүгээр асуудалдаа оръё.

**Нэг.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**
/Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн
2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Бүлгийн дарга. Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг нэг өдрийн завсарлага авсан.

Завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ үг хэлнэ.

Ж.Бат-Эрдэнэ даргын микрофон өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр нэг өдрийн завсарлага дууссаныг мэдэгдэж байна.

Ингээд бас 2025 оны 09 сарын 30-ны өдөр Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хойшлуулах санал хүргүүлсэн байгаа. Энэ саналаа бас буцаж татаж авч байна.

Х.Булгантуяа: Одоо Байнгын хорооны саналаар Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар үргэлжлүүлэн санал хураалт явуулна.

Ж.Бат-Эрдэнэ дарга үг хэлсэнтэй холбогдуулан бүлгийн завсарлага дуусаж байна. /алх цохив/

Бид хэдийн баталсан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу байгаа.

О.Цогтгэрэл дарга, Ардчилсан намын бүлгийн дарга хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан, завсарлага авахтай холбогдуулан үг хэлье гэсэн байна.

Монгол Ардын намын. Тийм. С.Бямбацогт дарга аа, Хэрэг эрхлэхийн дарга тусгай дэгээр явна гэсэн дэг байхгүй. С.Бямбацогт дарга биш. Уучлаарай. О.Цогтгэрэл дарга. Ардчилсан намын бүлгийн дарга завсарлага авахтай холбогдуулан, хэлэлцэх асуудалтай, завсарлага авахтай холбогдуулан үг хэлье гэсэн байна.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе.

Өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудал хоёр хууль байна. Хөдөө аж ахуйн хууль, Хүнсний хууль.

Энэ хоёр хууль дээр, тэр тусмаа Хөдөө аж ахуйн хууль дээр завсарлага авах үндэслэлүүд байгаа юм. Энэ хуулиар яг шийдэж байгаа асуудлын цар хүрээг харахад хөдөө аж ахуйг гэсэн мөртлөө зөвхөн нэг мал аж ахуйн тухай дурдагдсан, тунхагийн шинжтэй, шийдэж байгаа асуудал багатай.

Ийм учраас завсарлага авах үндэслэл нэгдүгээрт нь байна гэж үзэж байгаа юм. Үүнийг нь бид хэлэлцэж, ярилцаж, сонсох.

Хоёрдугаарт нь, өнгөрсөн долоо хоногт Ардчилсан намын удирдах байгууллагын Улс төрийн зөвлөлийн шийдвэр гарч бүлэгт тодорхой чиглэл өгсөн. Хоёр асуудлаар.

Улсын Их Хурлын даргын ёс зүйн асуудлаар. Мөн улсын төсөв эзэнгүйдэж байгаа асуудлаар байр суурь илэрхийлж, шийдвэр гарга гэдэг чиглэлийг Ардчилсан намын бүлэгт Улс төрийн зөвлөлөөс өгсөн.

Ийм учраас яг одоо бид хурлаас гарч Ардчилсан намын бүлгийн хурлыг зарлаж, бүлгийн хурал дээр эдгээр асуудлууд болоод энэ завсарлагатай холбоотой асуудлыг бид нэгдүгээрт нь ярилцана.

Хоёрдугаарт нь, манай гишүүд бүлгийн улс төрийн зөвлөлийн шийдвэртэй холбоотой гишүүд бүгдээрээ хурлыг орхин гарч. Тэгэхдээ та нар ирцдээ ороод орхин гарч бүлгийн хуралд оролцох ёстой.

Намын удирдах байгууллагын шийдвэр надад хамаагүй гэж байгаа гишүүд байвал энд суугаад үлдэж болно. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, бид яг энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой ажил саатуулах үүднээс завсарлага гэж биш, одоо ингээд завсарлага авахаа болилоо. Та нар олонх ирцээ бүрдүүлээд хурлаа үргэлжлүүлээд яв. Ардчилсан намын бүлэг одоо хуралдаж тодорхой асуудлуудаар бас санал нэгтгэх ийм шаардлага байгаа гэдгийг хэлье.

Х.Булгантуяа: О.Цогтгэрэл дарга аа. Харин тийм.

О.Цогтгэрэл дарга аа, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу нам, эвслийн бүлэг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах. Завсарлага авахдаа үндэслэл, хугацааг тодорхой хэлж, энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулж авах ёстой.

Түүнээс биш намынхаа гишүүдийг орхиод гаръя гэдэг уриалгыг дэвшүүлэхэд уг нь намын бүлгийн дарга та сая үг авах дэгийн тухай хуулийн дагуу байхгүй шүү дээ. Энэ бол танай намын бүлгийн гаргасан шийдвэр байж болно. Тэрийгээ бүлэг дээрээ танилцуулаад, бүлгийн гишүүд Та бүхэн өөрсдөө тэр асуудлаа шийдэх ёстой.

Тэгэхээр та сая завсарлага авъя гэж үг аваад, тэгснээ орхин гаръя гэдэг уриалгыг дэвшүүлээд өөрөө та ингээд дэгийн тухай хуулиа зөрчөөд байх юм. Бүлгийн даргын хувьд.

Завсарлага авсангүй. Ирцдээ орсон. Бид чуулганы хуралдааныг орхин гарлаа гэж байна.

Улс орны олон чухал асуудлууд бидний өнөөдөр чуулганы хуралдаануудыг хараад, шийдвэрүүдийг хараад хүлээгдэж байгаа олон зүйл байгаа.

2026 оны төсвийг бид хуулийн дагуу хэлэлцэн батлах үүрэгтэй.

Улсын Их Хурал 2026 оныхоо төсвийг жишээлбэл хуулийн дагуу хэлэлцэн батлах үүрэгтэй. Өнөөдөр бас тун удахгүй ингээд өвөлжилт, ингээд дээрээс нь нэмээд өвлийн бэлтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурал шийдвэрлэх олон асуудлууд улс төрчидтэй холбогдуулан уягдах ерөөсөө ёсгүй.

Тэгэхээр Улсын Их Хурал бол ард түмний өмнө өргөсөн тангарагтаа бүгдээрээ хийх ажлаа хийх л ёстой. Тэр аль нэг намын хурал нь болж байна уу, энэ бүх асуудал дээр хууль хяналтынх нь байгууллага нь хийдэг ажлаа хийдгээрээ хийх ёстой. Бид эндээ хуралдаад төсвөө батлаад 2026 оны 01 сарын 01-нээс төрийн үйл ажиллагаа тасралтгүй явах эрх зүйн орчныг нь бид бүрдүүлж өгөх үүрэгтэй байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа явагддагаараа явагдана.

Одоо Байнгын хорооны саналаар Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар үргэлжлүүлэн санал хураалт явуулахаар байгаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.5-д заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн. Эсвэл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг, гишүүн хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно гэж Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан байгаа.

Үүнийг манай Ардчилсан намын бүлгийн гишүүд өөрсдөө бид хамтдаа кнопдож, хамтдаа баталсан дэгийн тухай хуулиа Та бүхэн зөрчиж байна шүү. Зөрчиж байна шүү.

Тэгээд бид өөрөө өнөөдөр аль нэг намын хуралтай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг хуралдуулахгүй байх. Ялангуяа цаг хугацаандаа төсөв батлагдахгүй байх ийм байдалд бид хүргэж болохгүй шүү.

Өнөөдрийн хамгийн эхний санал хураалт явагдах гэж байгаа тул бүгдээрээ эхлээд санал хураалтад бэлэн байдлаа хангаад, нэг ирцийн санал хураалт явуулъя. Бэлдүүлье. Ирцийн санал хураалт. Ирцийн санал хураалт явуулъя. Ирцийн санал хураалт.

Гишүүд санал хураалтад бэлдсэн байна. Санал хураалт.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн.

1.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Санал хураалт. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

2.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 53.4 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

3.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураана. Санал хураалт. /алх цохив/

Гишүүдийн 54.5 хувь нь дэмжиж, санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы 09 дүгээр сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцлоо.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

“Хуулийн төсөл буцаах тухай” Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.14 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Б.Бейсен, Л.Соронзонболд, Г.Хосбаяр, Р.Батболд, Д.Үүрийнтуяа, У.Отгонбаяр, Ц.Идэрбат,

Л.Энхнасан, М.Ганхүлэг нараас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Их Хуралд Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг нэгдсэн хуралдааны санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай гэсэн байна.

“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. /алх цохив/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**
/Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн
2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг ажлын нэг өдрийн завсарлага авсан байгаа.

Завсарлагын хугацаа дууссан байна. /алх цохив/

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга үг хэлнэ.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Хүнсний тухай хуультай холбогдуулан авсан завсарлага дууссан тул хуралдаанаа цааш явуулахыг хүсэж байна.

Х.Булгантуяа: Ж.Бат-Эрдэнэ даргын микрофоныг нэмээд өгөөрэй.

Ж.Бат-Эрдэнэ: Мөн энэ хуультай холбогдуулаад 2025 оны 09 сарын 30-ны өдөр Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийг хойшлуулах саналыг хүргүүлсэн байгаа.

Энэ санал хүргүүлсэн албан тоотоо буцааж авч байна, татаж авч байна.

Тийм болохоор цаашаа хэлэлцээд явъя гэсэн ийм саналтай байна.

Х.Булгантуяа: Албан бичгээ буцааж татахаар, үргэлжлүүлэн хэлэлцэхээр албан бичгийг Ж.Бат-Эрдэнэ дарга өнөөдөр Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлсэн байгаа.

Тийм учраас үргэлжлүүлэн хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн хууль, санаачлагч Мэндбаярын Мандхай танилцуулна. Индэрт урьж байна.

М.Мандхай: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг танилцуулж байна.

Монгол Улс нэгдэн орсон буюу соёрхон баталсан хүний эрхийн түгээмэл тунхаглал, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын фактад хүн бүр хоол хүнс оролцуулаад өрхийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрх, нэн тэргүүнд өлсгөлөн, тэжээлийн доройтлоос ангид байх эрхийг онцлон заажээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2.1-д “хүнсний хангамжийн баталгаат байдлыг хангаж, физиологийн зохистой нормд нийцсэн хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.5-д “амьдралын хэрэгцээг хангасан эрүүл, ая тухтай, таатай орчныг бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана” гэж, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3-д Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэж тус тус заасан нь уг хуулийн төслийг боловсруулах үндэслэл болно.

Монгол Улсын Их Хурал 2012 онд баталсан Хүнсний тухай хуулийг баталж, хүнсний хангамж, хүртээмж, хүнсний шим тэжээллэг байдал, хүнсний баталгаат байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулсан.

Гэвч хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг дараах тоон баримтуудаар харуулж байна.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийн 54 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, 46 хувь нь импортын хамааралтай байгаа нь хүнсний хангамж хангалтгүй, эрсдэлтэй түвшинд байна.

Хүнсний хүртээмж нь газар зүйн байршлаас хамаарч харилцан адилгүй байгаа бөгөөд хөдөөд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил улсын дунджаас давж, хотод гурилан бүтээгдэхүүн, төмс, сахар, чихэрлэг хүнсийг улсын дунджаас давж тус тус хэрэглэж байна.

Хүнсний хүртээмжтэй байдал нь хүн амын дундах ядуурал, амьжиргааны түвшин, ажилгүйдэл, цалин орлогын хэмжээ, төрийн хөнгөлөлт, дэмжлэгээс шууд хамааралтай.

■ Статистикийн мэдээгээр ядуурлын түвшин

- ▶ 2016 онд **29.6 хувь**,
- ▶ 2018 онд **28.4 хувь**,
- ▶ 2020 онд **27.8 хувьтай** байсан бол

▶ 2022 оны байдлаар **27.1 хувь** болж буурсан байна.

Хэдийгээр ядуурлын түвшин буурсан ч ядууралд ойрхон байгаа хүмүүс аливаа сөрөг хямрал, эдийн засаг, үнэ, уур амьсгал, эрүүл мэнд гэх мэт үүсэхэд эргээд ядууралд өртөх эрсдэлтэй.

Эдгээр хүмүүсийн хувьд хүнс хүртэх боломж маш хангалтгүй байна.

2017, 2023 онд хийсэн хүн амын хоол тэжээлийн байдал үндэсний 5, 6 дугаар судалгааны дүнг харьцуулахад хүн амын дундах хоол тэжээлийн дутал буураагүй байгаа нь зохистой хооллох мэдлэг дадал дутмаг, хоол хүнсний хяналтгүй хэрэглээтэй холбоотой.

Шим тэжээлгүй хоол, хүнсийг хэрэглэснээс таргалах, өвчлөх зэрэг сөрөг үр дагаврууд илэрч байна.

Хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь хүнсний аюулгүй байдлыг хангах болон түүнд хяналт тавих тогтолцоо гажуудалд орсонтой холбоотой. Мөн

дотоодын үйлдвэрлэл, хүнсний шимт байдал, хүнсний зохистой хэрэглээтэй холбоотой харилцааг дутуу зохицуулсантай холбоотой байна.

Иймд хууль тогтоомжийн хэрэгжилтийг үр дүнтэй, зохистой болгох зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж дараах харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд, олон улсын жишигт нийцүүлэн хүнсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо, түүнтэй холбогдох зохицуулалтыг иж бүрэн тусгана.

Тухайлбал, хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэлийг тодорхойлж, тэдгээрийн боловсруулах үндэслэл болон тандан судалгаатай холбоотой зохицуулалтыг тусгана.

Мөн хоол, хүнснээс гаралтай халдварт бус өвчлөл бууруулах зорилгоор хүн, мал, амьтан, ургамал, байгаль орчны эрүүл, аюулгүй байдлын харилцан шүтэлцээг хангах зарчмыг тусгалаа.

Хүнсний бүтээгдэхүүн, аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “хүнсний сүлжээ” гэж хүнсний анхан шатын үйлдвэрлэл эрхлэгч хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, баяжуулах, дахин боловсруулах, савлах, тээвэрлэх, хадгалах, нөөцлөх, худалдах, экспортлох, импортлох, хоол үйлдвэрлэх, хүнсний бүтээгдэхүүнийг тусламжаар авах, өгөх үйл ажиллагааг ойлгохоор заасан.

Гэвч Хүнсний тухай хуульд хүнсний сүлжээнээс хүнсний тээвэрлэлт, хадгалалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний худалдаа, түгээлт, хүнс, импортоор авахтай холбоотой харилцаа зохицуулалтгүй орхигджээ.

Иймд эдгээр зохицуулагдаагүй харилцааг тусгасан хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх шаардлагын үүднээс хэрэглэгчдэд төөрөгдөл үүсгэж байгаа “хүнсний аюулгүй байдал”, “хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэсэн нэр, томъёоны нэршлийг өөрчлөх, хүнсний аюулгүй байдлын онолын үзэл баримтлалд үндэслэн “хүнсний баталгаат байдал”, “хүнсний эрүүл ахуй”, “хүнсний сүлжээ” гэсэн нэр томъёог өөрчлөх, мөн “зохицуулах үйлчилгээний хүнс” гэсэн шинэ нэр томъёог нэмж тусгана.

Энэхүү хуулийн 17 дугаар зүйлд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч зохистой дадал, хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснээ олон улсын хэмжээнд магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар баталгаажуулж болохоор байсныг өөрчилж, үндэсний баталгаажуулалтын байгууллагаар заавал баталгаажуулахыг үүрэг болгож хариуцлагыг дээшлүүлнэ.

Монгол Улсын хүнсний импортын хамаарлын түвшнийг бууруулах, экспортыг дэмжих үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, хүн ардад хүнсний зөв зохистой хооллох хэрэглээ, мэдлэг, хандлага төлөвшүүлэх, соён

гэгээрүүлэх, сургалт, сурталчилгаа хийхэд эрдэм шинжилгээний байгууллагын оролцоо чухал байна.

Иймд эрдэм шинжилгээний байгууллага, түүний чиг үүрэгтэй холбогдсон зохицуулалт тусгасан.

Салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, тогтвортой ажиллуулах зорилгоор мэргэжлийн сургалт, мэргэжлийн зэрэг олгохтой холбогдсон харилцааг тусгасан.

Мөн төр, хувийн хэвшлийн хамтын хүчин чармайлтаар салбарын хүний нөөцийг чадавхжуулснаар хүнсний сүлжээний бүхий л үйл ажиллагаа мэргэжлийн удирдлагаар хангагдах нөхцөл бүрдэнэ.

Хүнсний тухай хууль 5 бүлэг, 20 зүйл, 26 заалттай.

Хуулийн төсөлд 6 зүйл, 12 хэсэг нэмэхээр, 4 заалтад үг хасахаар, 25 заалтыг өөрчлөхөөр, 1 зүйлийг өөрчлөн найруулах, 3 хэсэг, 2 заалтыг хүчингүй болгохоор тусгасан бөгөөд эдгээр өөрчлөлт нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нийт заалтын 43 хувьд хүрнэ.

Иймд хуулийн төслийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулсан болно.

Х.Булгантуяа: Төслүүдийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Уянга танилцуулна.

Индэрт урьж байна.

Б.Уянга: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, хүнсний хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд үндэслэн хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиглэл, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог оновчтой болгох, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог сайжруулах, эрүүл ахуйн шаардлага хангасан баталгаатай, тэжээллэг, эрүүл хүнсний хэрэглээтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор хуулийн төслийг боловсруулсан

бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагаас нэмэлт зардал гарахгүй байхаар тусгажээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг d-parliament.mn цахим хуудаст байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг Хүнсний тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үр дагаврын үнэлгээгээр хуулийн хэрэгжилт хангалтгүй, нэмэлт, өөрчлөлтийн төсөл батлагдвал хуулийн хэрэгжилт хангагдах боломжтой эсэх, Монгол Улсад хүнсний аюулгүй байдал хангагдахгүй байх нөхцөл, шалтгааныг хүнсний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд зохистой дадлын стандартыг нэвтрүүлээгүй байна гэж дүгнэсэн нь бодитой эсэх, хуулийн төсөлд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг дэмжих зохицуулалтад туссан эсэх,

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайхан төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улаанбаатар хотод нийлүүлж байгаа малын мах малчны гар дээрээс дундын зуучлагчаар дамжин зах, худалдааны төвүүдээр борлуулагдаж, хүнс үйлдвэрлэл рүү нийлүүлэгдэж байгаад хяналт тавих удирдлагын тогтолцоотой болгож байгаа нь хоол, хүнсний үйлдвэрлэл эрхлэхэд шаардагдах тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэх эрсдэл үүсгэх эсэх,

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хуулийн төсөлд сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг Боловсролын яам, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн ханган нийлүүлэлтийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймаг, нийслэлийн удирдлагууд хариуцахаар төсөлд тусгасан нь оновчтой эсэх, салбарын яам дангаараа хариуцах боломжтой эсэх, хүнсний чиглэлээр ажиллах эрдэм шинжилгээний байгууллагын эрх зүйн орчин тодорхой болох эсэх талаар,

Улсын Их Хурлын гишүүн А.Ундраа хуулийн төсөл нь хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж чадсан эсэх, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлийн асуудлыг хянах, хариуцан ажиллах хүний нөөцийг төсөвт тусгасан талаар,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал монгол хүний бие махбодын хэвийн үйл ажиллагаа, өсөлт хөгжилтийг хангах, илч зарцуулалтыг нөхөхөд шаардагдах хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодисын тухай ойлголт, нормыг шинэчлэх асуудлыг цаашид боловсронгуй болгох талаар, импортоор оруулж ирж байгаа хүнсний хяналтын асуудал, гарал үүсэл, мөшгөлт, баталгаажуулалтын асуудал туссан эсэх,

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэх талаар Засгийн газрын саналыг авсан эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хэлэлцүүлгийн шатад хуулийн төслийг сайжруулах, хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудлыг хариуцах, холбогдох байгууллагын чиг үүргийг тодорхой болгох,

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хүнс үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг жижиг, дунд үйлдвэрлэгч, хүнс үйлдвэрлэгчдийн саналыг хуулийн төсөлд тусгасан эсэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг төрийн захиалгаар хийх, судалгааны ажилд шаардагдах төсвийг төр хариуцах талаар болон ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, мах, малын гаралтай бүтээгдэхүүнд тавигдах хяналтыг сайжруулахад анхаарах талаар санал хэлсэн болно.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Х.Булгантуяа: Та бүхэнд ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Балганы Алтанцэцэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын хуулийн мэргэжилтэн, Дэлэгийн Энхмаа Хүнсний аюулгүй байдлын шинжээч, доктор (Sc.D), Жамбалын Туяацэцэг зөвлөх инженер, доктор (Ph.D), дэд профессор.

Одоо Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна.

М.Сарнай гишүүн байхгүй байна.

Нийт 9 гишүүний нэр ирсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан. З.Мэндсайхан гишүүн байхгүй байна. П.Батчимэг гишүүн байхгүй байна. Ц.Баатархүү гишүүн байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэбат.

С.Эрдэнэбат: Хүнсний тухай хуулийг дэмжиж байгаа. Хэдэн зүйл тодруулж асууя.

Хүнсний нэмэлт бүтээгдэхүүнүүд гэж зүйлүүд байна. Үүнийг хяналт шинжилгээ, баталгаа. Энэ зүйл манай дээр яаж явж байгаа. Энэ хууль дээр яаж тусгасан бэ? Орсон байгаа юу?

Мөн иргэдийн зүгээс сүлжээгээр. Манай байж болох бүх л инфлүүсерүүд болон энэ хүнсний нэмэлт бүтээгдэхүүнийг сурталчилдаг. Үүнд нь иргэд ямар нэгэн баталгаа, нотолгоо гэдэг энэ зүйлийг хаанаас үзэж болох вэ гэдэг зүйлийг их асуудаг.

Ялангуяа манай тэтгэврийн хөгшчүүд, өвдөж зовсон хүмүүс, тэгээд янз бүрийн хүмүүс маань энэ зүйл дээр эдийн засгийн хувьд болон мөн нөгөө талаар бие махбодоор хохирох явдал байдаг.

Тэгээд энэ тал дээр хийсэн судалгаа байна уу? Энэ дээр ямар нэгэн хяналт зүйл байна уу? Үүнийг ер нь хэрхэн яаж зохицуулах вэ? Хүнсний тухай хуулиараа зохицуулах уу хэдүүлээ.

Хүнс болон эрүүл мэндийн салбарын дунд нь хаягддаг асуудал байгаа. Эргээд үзэхээр энэ нь өөрөө нэлээн сошиал ертөнц хөгжсөн орчинд асар их газар авах хандлагатай юм билээ. Бараг зарим нь үндсэндээ үүнийг уугаад идэх юм бол одоо ерөөсөө эм уугаад хэрэггүй, эмнэлэгт хэвтээд хэрэггүй гээд тавьдаг. Үүнийг нь нотолж баталсан ямарваа нэгэн үнэлгээ, нотолгоо, судалгаа, статистик мэдээлэл ер нь байдаггүй.

Тийм учраас энэ тал дээр одоо яг энэ хууль дээр ямар зохицуулалт тусгасан байгаа вэ?

Х.Булгантуяа: Хууль санаачлагч Мэндбаярын Мандхай хариулъя.

М.Мандхай: С.Эрдэнэбат гишүүнд баярлалаа. Маш чухал асуудлыг хөндлөө.

Ер нь хүнсний нэмэлт бүтээгдэхүүнтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалт Монгол Улсад Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулагддаг.

Сая 2024 онд шинэчлэн найруулсан 4.1.40 дээр эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн гэж хүний бие махбодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор

тодорхой хэлбэр, тунгаар, хүнснээс гадна нэмэлтээр хэрэглэх байгалийн болон нийтлэг гаралтай тарилгаас бусад хэлбэрийн бүтээгдэхүүнийг гэж тусгасан байдаг.

Мөн энэ хуулийн үйлчлэх хүрээ 3 дугаар зүйл дээр 3.1 энэ хууль хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнтэй холбогдсон харилцаанд үйлчлэх бөгөөд мал, амьтны эрүүл мэндийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлттэй холбогдсон харилцаанд үйлчлэхгүй гэсэн зохицуулалттай.

Тэгэхээр Хүнсний тухай хууль буюу энэ ерөнхий хуульд тусгагдаагүй. Энэ өөрөө бүр нарийвчилсан хяналтын асуудал болон яг ямар бүтээгдэхүүн хамрах асуудал энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулагддаг.

Х.Булгантуяа: С.Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр эрүүл мэндийн талаас ярихаар үүнийг хүнсний хуулиар зохицуулах ёстой гэж яриад байна.

Тэгэхээр үүнийгээ л яг дунд нь хаяхгүй хэдүүлээ тусдаа хуулиар нарийвчилж зохицуулах хэрэгтэй юм байна гэж. Би түүн дээр санал нэг байна. Яах вэ, хүнсний ерөнхий хууль дээр энэ талаар тодорхой хэлэлцүүлгийн явцад нэмэлт зүйлүүдийг оруулах шаардлагатай болов уу гэж бодож байна.

Хоёрдугаарт, нэг зүйл асуухад. Нэг зүйлийг л сонсоод. Манай энэ бяслагийг хүнсний хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг дээд тал нь 1 жил хадгална гэдэг стандарттай юм шиг байна. Тухайлбал, бяслаг гэхээр чинь манайд бяслаг үйлдвэрлээд бяслаг чинь 2, 3 жил болж байж хамгийн сайн чанарын бяслаг болдог гэхэд манай хүнсний хуульдаа 1 жил байна гээд заасан. Устгахаас өөр аргагүй ийм бодолтой болсон.

Иймэрхүү зөрөлдөөнтэй гэдэг юм уу, ийм зүйлийг яаж зохицуулах юм бэ? Энэ хуулиар.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нэмж хариулъя.

М.Мандхай: Манай хүнсний мэргэжлийн судлаач нар бяслагийг хадгалахтай холбоотой асуудал дээр хариулт өгөөрэй.

Ер нь Хүнсний тухай хуульд хүнсний нэмэлт бүтээгдэхүүнтэй холбогдох ерөнхий зарчмын асуудлуудыг энэ хуульд тусгаж оруулах нь зүйтэй.

Гэхдээ нарийвчилсан асуудлуудыг илүү Хүнсний бүтээгдэхүүн, аюулгүй байдлын тухай хуульд оруулбал илүү процессын нарийвчилсан хууль байгаа болохоор тийшээгээ тусгаж оруулбал зүгээр байх гэж бодож байна.

Тэгэхдээ хэлэлцэх эсэх шийдэгдээд явахаар ажлын хэсэг гараад явах юм бол үүнтэй холбоотой асуудлуудыг нарийвчлаад хэлэлцэж болох байх гэж бодож байна.

Тэгээд бяслагтай холбоотой асуултуудыг манай экспертүүд хариулна.

Х.Булгантуяа: Нэмж ажлын хэсгийн микрофоноос 4 номерын микрофон.

Ж.Туяацэцэг: Сайн байцгаана уу? Бяслагтай холбоотой асуудлыг би хариулъя.

Тэр тухайн бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэлийн технологийн онцлог байдаг. Зарим бяслаг нь жилийн хугацаатай, зарим нь 3 жилийн дараа боловсорч гүйцдэг гэсэн үг.

Тэгэхээр худалдаанд гарснаас хойш 1 жилийн хугацаанд хадгална гэсэн үг. Түүнээс тэр технологи нь гүйцээгүй, бойжилт нь явж дуусаагүй бол худалдаанд гарахгүй гэсэн үг шүү дээ. Гарснаас нь хойш үүнийгээ бид яах нь вэ, 1 жилийн хугацаанд хадгалах буюу 1 жилийн хугацаанд хэрэглэж тусгах ёстой гэсэн үг. Ийм хариулт өгье.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатарын Ганбаатар. Байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Баяртай байгаа.

Хөдөө аж ахуйн хууль, Хүнсний хууль гэх мэтчилэн нэг хуулийг нэг хүн авторлаад орж ирж байгаа нь. Ингэснээрээ маш хүлээлттэй, нийтийн эрх ашигт маш чухал. Ялангуяа эрүүл мэндийн салбарт маш том урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, одоо бидэнд тохиолдоод байгаа том том асуудлуудыг багасгах ийм гоёул суурьтай хууль батлагдах гээд ярилцаад сууж байгаад.

Цөөхөн хэдэн асуудал байгаа.

М.Мандхай ч үүнийг ер нь мэдэж байгаа даа.

▷ **Нэгдүгээрт,** Хүнсний баяжуулалтын хууль гэж маш чухал хуулийг нэлээн асуудлууд болж байж 2017 онд батлагдсан.

Хэрэгжилт нь бага байгаа. Тэгэхдээ Хүнсний баяжуулалтын хуультай одоо орж ирж байгаа хууль маань яаж уялдаж байгаа билээ гэдэг асуудал байна.

▷ **Хоёрдугаарт**, би асууж байсан. Хүнстэй холбоотой олон нийтийг хамарсан хордлого ч гэдэг юм уу, эсвэл дэлхийд харанга дэлдээд байгаа бактерийн дасал гэдэг юм уу даа, энгийн хэлээр хэлэх юм бол. Энэ асуудлуудыг эрүүл мэндийн үнэлгээ, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ энэ хуульд орсон уу?

▷ **Гуравдугаарт**, шим тэжээлтэй холбоотой. Шим тэжээл гэдэгт бид эсвэл нэг калори яриад л, эсвэл хүн нэг турж, таргалах тухай асуудал яриад байдаг.

Үнэндээ энэ чинь маш нарийн шинжлэх ухааны үндэслэлтэй, маш олон бичил шим тэжээлүүд байгаа. Тийм ээ. Тэр нь хүний биед ороод, цусаар дамжаад, идэвхтэй болоод ажиллах уу, ажиллахгүй юу. Хүн хүний бие биеийн онцлогууд янз янз байдаг боловч яг энэ асуудлаараа бид нарийвчлаад мэдээллийн сан дээр тулгуурлаж оруулж байгаа юу? Оруулж байгаа бол ямар байдлаар оруулж. Энэ дээрээ хамгийн гол нь мөнгө, санхүү, төгрөгийг нь хуультайгаа хамтарч оруулж ирж байгаа юу?

Нэмээд энэ хүнстэй холбоотой хуулиудын хэрэгжилт түрүүн 27, 40 хэд гээд маш бага байгаа. Энэ хууль батлагдсанаараа хэрэгжилт нь сайжирна, тэдэн хувийн хэрэгжилттэй болно гэсэн баталгаа нь юу байна аа?

Дараагийн асуулт нь, төрийн худалдан авалттай холбоотой асуулт байна. Төрөөс маш их мөнгө зарцуулж сургууль, цэцэрлэг, нөгөө хүчний байгууллага гэх юм уу даа. Ардын арми цэрэг гэх мэтийн худалдан авалтуудыг хийдэг. Эдгээр дээр үнэхээр шим тэжээлтэй, хэрэгтэй, ялангуяа хүүхэд, багачуудын тархины хөгжил, биеийн хөгжилд зайлшгүй шаардлагатай шим тэжээлийг өгч болдог эрүүл сайн зохистой хоол хүнсийг илүү хямдралтай, илүү хүртээмжтэй, илүү боломжтой болгох тал дээр энэ хууль дээр хууль санаачлагч яаж идэвх санаачилга гаргаж ажилласан бэ?

Эдгээр асуудлуудаас болоод дараа дараагийн нэлээн олон асуудлууд хөндөгдөнө. Баярлалаа.

Х.Булгантуяа: Хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай хариулъя.

М.Мандхай: Маш мэргэжлийн хүний чухал асуудлуудыг хөндөж асуусанд баярлалаа.

Тэгээд эхний асуулт бол энэ Баяжуулах хүнсний тухай хууль 2017 онд батлагдсан. Үндсэндээ баяжуулах хүнс манайд хэрэгжилт байхгүй явж ирсэн.

Тэгээд Хүнсний тухай хууль энэ ерөнхий хууль дээр бид илүү эрүүл хүнс, хүнсний нийгмийн эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах зорилго бүхий бүтэцтэйгээр одоо энэ хүнс.

Тэгэхээр энэ заалтыг илүү баяжуулсан хүнсийг өргөн утгаар нь хамруулж ойлгох боломжтойгоор энэ хуульд тусгасан.

Тэгээд мөн 8.2.1, 8.2.3 дээр хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад төрийн үүрэг гэж бас байгаа. Энэ дээр баяжуулалтын төрийн зохицуулалт, хяналттай уялдана гэж харж байна.

Мөн 10.1.6, 10.1.8 дээр Үндэсний хөтөлбөр, хүнсний стандартын хэрэгжилтийг хангах гэдэг зохицуулалт дээр ерөнхий хууль, ер нь хүнстэй холбоотой салбар хуулиуд дээр энэ ерөнхий хуульд заагдсан үндэсний хөтөлбөр, хүнсний стандартын хэрэгжилт, хүнсний хангамж, аюулгүй байдал гээд нийгмийн эрүүл мэнд жишээлбэл энэ эрсдэлийг бууруулахтай холбоотой ерөнхий зохицуулалт ерөөсөө хүнсний баяжуулалтын стандарт, аргачлалтай уялдуулах, мөн баяжуулалтыг хэрэгжүүлэхэд төрийн тэр зохицуулалт, хяналтыг сайжруулах гэсэн эдгээр утга агуулгаар тусгагдаж оруулсан байгаа.

Тэгээд мөн хүүхэд, багачуудад хоол хүнсийг өгөх, ялангуяа ерөнхий боловсролын сургуульд одоогийн байдлаар зөвхөн бага ангийн хүүхдүүдэд хоол хүнсийг хангаж байгаа.

Ингээд дунд болон ахлах хүүхдүүдэд хоол өгдөггүй. Бага ангийн хүүхдүүдэд олгож байгаа хоол ойролцоогоор 300 гаруй мянган хүүхдийн хоол хамрагддаг.

Гэхдээ яг шим тэжээлийн судалгаагаар үндсэндээ 50 хувьд нь ч өөрөө энэ шим тэжээл хүрдэггүй. Хоолных нь шим тэжээл нь 50 хувьд нь ч хүрдэггүй.

Тэгэхээр үүнийг нэмэгдүүлэх шаардлагатай гэдгийг олон судалгаагаар гаргаж ирсэн байгаа.

Тэгэхээр бид зөвхөн хүнсний ерөнхий хууль, ялангуяа хэрэгжүүлэхтэй холбоотой бусад салбар хуулиудыг зайлшгүй хэрэгжүүлэх дээр онцгой анхаарах шаардлагатай.

Ингэснээр бид хүүхдийн шим тэжээлийн хоолыг нэмэгдүүлэх, цаашлаад улсын төсөвт ч гэсэн шим тэжээлийг нэмэгдүүлэхтэй холбоотой төсвийг суулгаж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Үүнтэй холбоотой техникийн асуултууд дээр манай ажлын хэсэг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Ажлын хэсгийн 4 номерын микрофоноос нэмж хариулъя.

Д.Энхмаа доктор.

Д.Энхмаа: Ажлын хэсэг. Д.Энхмаа. М.Мандхай гишүүн хариулсан.

Баяжуулсан хүнсний тухай хууль Хүнсний тухай хуулийг дагасан хууль байгаа. Энэ дээр зохицуулалтыг өөрчлөөгүй. Урт хугацаандаа хууль хэрэгжсэнээр ямар үр дагавартай гарах вэ гэдгийг ажлын хэсгээс дүгнэлт гаргасан.

- ▶ Богино хугацаанд,
- ▶ дунд хугацаанд,
- ▶ урт хугацаандаа өөрчлөлтүүд орно. Жишээлбэл:
 - Хяналт болон зохистой дадлын хэрэгжилт 30-аас 40 хувь сайжирна.
 - Импортын хүнсний мэдээллийн хүртээмж 40-өөс 50 хувь богино хугацаандаа сайжирна.
 - Хүнсний зөрчил илрүүлэх чадамж 20-иос 30 хувь нэмэгдэнэ.
 - Дунд хугацаанд буюу 3-аас 5 жилд лабораторийн шинжилгээний найдвартай байдал 50-иас 60 хувь өснө.
 - Эрүүл, зөв хүнсний хэрэглээ 40-өөс 50 хувь нэмэгдэнэ.
 - Олон нийтийн хооллолтын боловсрол ойролцоогоор... /минут дуусав/

Х.Булгантуяа: 4 номерын микрофоныг нэмж өгье.

Д.Энхмаа: Урт хугацаандаа хүн амын шим тэжээлийн дутал 20-иос 30 хувь буурна гэж тооцсон.

- Архаг өвчлөл 10-аас 20 хувь буурах хандлагатай.
- Монголын хүнсний бүтээгдэхүүний экспортын өрсөлдөх чадварыг 30-аас 40 хувь нэмэгдүүлнэ.
- Хүнсний баталгаат байдлын тогтолцооны тогтвортой байдал 70-аас 80 хувь дээшилнэ гэсэн ийм прогноз гарсан байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нэмж тодруулна.

Д.Ганмаа: Баярлалаа. Би асуусан. Тийм ээ. Судалгаа, шинжилгээн дээр үндэслэсэн “Шим тэжээлийн мэдээллийн сан” гэж юм байгаа. Тийм ээ. FOOD COMPOSITION DATABASE гээд.

Энэ амьдрал дээр хэрэгжээд явахын тулд мөнгө төгрөг, санхүү суусан уу? Энэ хууль хэрэгжих боломжийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гаргах өөрчлөлтүүдээ яаж хийхээр төлөвлөж байгаа вэ?

Хэрэгжилт яг бий болно гэдэг дээр ямар GUARANTEE өгч байгаа вэ гэсэн асуултууд байсан. Тийм ээ.

Х.Булгантуяа: М.Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Баярлалаа.

Хүнсний мэдээллийн тогтолцоо хуулийн төслийн 9 дүгээр зүйл дээр нарийвчилж тусгаж өгсөн байгаа. Тусгай бүлэг байгаа.

Үүнтэй холбоотой мэдээлэл “нийлүүлэлт”, “аюулгүй байдал”, “шим тэжээл”, “хэрэглээ”-ний талаарх мэдээллийг цуглуулах, бүртгэх, үнэлэх тогтолцоог илүү бий болгох шаардлагатай байна гэж үзсэн бөгөөд тэгээд энэ хуульд бий болгох зорилготойгоор тусгасан.

9.1.1 дээр хүнсний хангамж, шим тэжээл, хэрэглээний талаарх мэдээллийг бүртгэх.

9.1.3 дээр эрсдэлд суурилсан үнэлгээ хийх мэдээллийн санг бүрдүүлэх.

Мөн үнэлгээтэй холбоотой асуудал дээр төсөлд шим тэжээлийн мэдээллийг цуглуулах, ангилах, ашиглах үндэслэл бүрэн тусгагдсан байгаа.

Ингээд одоо мэдээлэл статистик дээр, яаман дээр лаборатори гээд олон... /минут дуусав/

Х.Булгантуяа: М.Мандхай гишүүн гүйцээж хариулъя.

М.Мандхай: Ингээд мэдээллийн дата бааз энд тэнд явдаг. Хоорондоо зөрүүтэй байдаг учраас бид хүнсний баталгаат аюулгүй байдлыг тогтвортой байлгах үүднээс ер нь нэгдсэн цахим мэдээллийн санд оруулж, илүү бодлого боловсруулалт, хяналт, үнэлгээ хийхэд ашиглая гэсэн зориулалтаар тусгасан байгаа.

Санхүүжилттэй холбоотой асуудал 10.3.2 дээр улсын төсвийн хүрээнд хүнсний хангамж, шим тэжээл сайжруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгасан.

Гэхдээ шим тэжээлийн бие даасан санхүүгийн зохицуулалт, татаас, урамшууллын нарийвчилсан хэлбэр төсөлд яг одоо тодорхой заагдаагүй байгаа. Үнэлгээтэй холбоотойгоор санхүүжилт хангах үүргийг төр хүлээж байгаа.

Мөн ерөнхий төсөвт багтах байдлаар тусгасан. Тэгээд шим тэжээл сайжруулах тусгай сан, гадаадын донорын хамтын ажиллагааг урамшуулах, дэмжих механизмыг ер нь тусгах шаардлагатай гэж үзэж байгаа.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг.

М.Ганхүлэг: Харамсалтай байна аа.

Монгол Улсыг хөдөө аж ахуйн орон гэж ярьдаг. Хөдөө аж ахуйн суурь хуулийн тухай асуудал бид ярьж байна.

Хүнсний аюулгүй байдал, хүнсний эрүүл ахуй, Хүнсний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудал ярьж байна. Сая бараг 20-иод гишүүд асуулт асууж, үг хэлэх ийм хуваарьтай байсан боловч 3-хан гишүүн үлдэж байна. Бусад нь тодорхой улс төрийн нөхцөл байдлын үүднээс үндсэн ажлаа үл огоорч улс төрийн нөхцөл байдлыг далимдуулж энэ ажлуудыг гацаах нөхцөл рүү орж байна.

Тийм учраас нийгмийн хүн амын чухал олон жил ярьсан хуулийн томоохон төслүүд орж ирж байгаатай холбогдолтойгоор Ардчилсан намынхан болон тодорхой гишүүдийг ажилдаа хариуцлагатай хандахыг хүсье.

Дотоодын, улс төрийн намуудын өөрчлөлтүүд явахад нэг нэгнийгээ бид бүхэн дэмжээд тодорхой амжилт хүсээд явж байсан улс төрийн соёл байсныг манай олон нийт анзаарсан байх аа. Гэтэл одоо аль нь яаж хандаж байна вэ гэдгийг эндээс дүгнэлт хийх нь зөв байх аа гэж бодож байна.

Яг Ардчилсан намын өөрсдийн яг бүлгийн дүгнэлт үү, улс төрийн зөвлөл нэрийдлээр тодорхой хуучны улс төрчид үүний цаана байна уу гэдгийгээ бид бүхэн анзаарах хэрэгтэй. Ийм санаархлууд байгаа бол С.Баярцогт тэргүүтэй хуучны улс төрчид энэ санаархлаа татаач ээ. Энэ төрийн ажил, үйл ажиллагааг гацаах гэж байгаа тодорхой үйл ажиллагаа явах ажилд саад хийж байгаа энэ байдлаа татаач ээ гэдгийг би анхааруулж хэлье.

Энэ хэрээс хэтэрч болохгүй ээ. Дотроо асуудлаа шийдээд энэ ажлууд цаашаа үргэлжлээд явах ёстой.

Төсвийн тухай асуудал, ENTRÉE-гийн тухай асуудал, мөн салбарын суурь хуулиуд гээд олон асуудлууд бид бүхнийг хүлээгээд байж байна. Одоо асуудлаа цэгцлээд ажилдаа орцгооё гэж уриалж хэлье.

Хөдөө аж ахуйн тухай хууль дээр би асуусан. Хууль санаачлагчтайгаа хамт би энэ асуудлыг өргөн барьсан. Энэ утгаараа хуулийн хэлэлцүүлэг, хэрэгцээ шаардлага, хуулийг өргөн барьж байгаа гол агуулгаа анхны хэлэлцүүлэг дээр иргэд, олон нийт, гишүүдэд дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч ээ гэдэг ерөнхий асуултаа би асууя.

Аль түвшинд ямар ямар хэлэлцүүлгүүд өрнөсөн бэ гээд.

Мэргэжлийн судлаачид энд хүрэлцэн ирсэн байна. Гишүүдэд Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага юун дээр тулгарсан бэ гэдгийг энгийнээр болон тодорхой анхаарал хандуулах зайлшгүй

шаардлагатай байгаа талаас нь Та бүхэн байр сууриудаа хэлж мэдээлэл өгөөч ээ гэж хэлэх байна.

Ерөнхий хоёр асуудал байгаа. Нэг талдаа хүнсний аюулгүй байдал, гарал үүслийн баталгаа, эрүүл хүнс хэрэглэхтэй холбогдолтой асуудал байгаа.

Тэгэхээр бид бүхэн уламжлалт болон орчин үеийн нөхцөл байдалд нийцсэн үйлдвэрлэлийг, хүнсний бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгч нартаа өгөх нэг талын зорилго, зорилт байж байна. Нөгөө талдаа бэлэн биш жижиг, дунд өрхийн үйлдвэрлэл, аж ахуй эрхэлж байгаа иргэд, олон нийт, малчид, үйлдвэрлэгч нар байна.

Тэгэхээр энэ хоёрын хооронд тодорхой зохицуулалт байгаа. Үүнийг тодорхой түвшинд бид бүхэн хуулиар байдаг юм уу хатуу зохицуулах гэхээр нөгөө анхан шат дээр байгаа хүмүүс маань үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй болдог.

Тэгэхээр энэ зохицуулалтыг бид бүхэн яг аль талдаа байж, яаж шийдэх вэ гэдэг дээр л гол энэ хуулийн агуулга зохицуулалтууд явдаг.

Тэгэхээр энэ чиглэлээр илүү дэлгэрүүлээд Та бүхэн мэдээлэл өгөөч ээ гэсэн саналтай байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай.

М.Мандхай: М.Ганхүлэг гишүүндээ баярлалаа.

Үнэхээр улс оронд хүнсний аюулгүй байдал харанга дэлдсэн, хавдрын өвчлөл нэмэгдсэн энэ хүнд нөхцөл байдалд бид байгаа.

Тэгээд энэ хууль маань 13 жилийн дараа нэмэлт, өөрчлөлт орж байгаа боловч харамсалтай нь Ардчилсан нам зөвхөн улс төрийн шийдвэр гаргаж бүгд энэ заалыг орхиж явж байгаа.

Ер нь улс төрийн ажил нэг талдаа байх ёстой. Төрийн ажил хэвийн явах ёстой. Тэгээд өнөөдөр хууль санаачлагчийн хувьд төрийн ажлыг хэвийн явуулахын тулд хуулиа хэлэлцүүлээд цөөхөн гишүүнтэй сууж байгаагаа хэлмээр байна.

Тэгээд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг манай ажлын хэсэг болон мэргэжлийн судлаачид хийгээд 37 хувьтай гаргасан байгаа. Бид 4 сард яг хуулийнхаа төслийг боловсруулаад **d-parliament** дээр тавиад 200 орчим иргэдээс, аж ахуйн нэгж болон мэргэжлийн төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудаас санал аваад саналыг хэлэлцүүлгийн явцад нэмэлт, өөрчлөлтүүдээ сайжруулсан байгаа.

Мөн бид 3 удаагийн хэлэлцүүлэг хийсэн. Эхний хэлэлцүүлгийг илүү мэргэжлийн болон яам, агентлаг, холбогдох байгууллагуудын дунд хийгээд 50, 60 орчим иргэд, байгууллагуудын төлөөллийн дунд хийсэн.

Дараа нь хоёр дахь хэлэлцүүлгийг зөвхөн эрдэмтэн судлаачид, яг энэ чиглэлийн олон улсын байгууллагуудын дунд хийгээд. Гурав дахь нь Улсын Их Хурлын гишүүддээ хэлэлцүүлэг өрнүүлж, саналуудыг тусгасан байгаа. Улсын Их

Х.Булгантуяа: Хурлын гишүүн Шинэбаярын Бямбасүрэн байхгүй байна.

Улсын Их Хурлын гишүүн Мөнхтөрийн Нарантуяа-Нара.

М.Нарантуяа-Нара: Өдрийн мэнд хүргэе.

Хүнсний тухай хуулийг, энэ асуудлыг угаасаа дэмжихээс өөр арга байхгүй. Яг одоо Монгол Улсад монгол хүний эрүүл мэнд, ялангуяа хүнсний аюулгүй байдал, баталгаажсан хүнсний асуудлаас болж монгол хүний эрүүл мэнд, амь нас хамгийн их далд дээсэн дөрөөн дээр байгаа.

Хавдрын бүх эмнэлгүүд, ер нь манай Монголын бүх эмнэлгүүд өвчтөнөөр дүүрэн байгаа нь хүнсний аюулгүй байдалтай маш холбоотой.

Тэгээд ийм чухал хууль хэлэлцэж байхад Ардчилсан нам. Сөрөг хүчний ажлыг ер нь ингээд л хурал хаяад л, хурлаас завсарлага аваад. Энэ бол ерөөсөө ингэж сөрөг хүчний ажлыг хийхгүй ээ.

Тийм л юм бол, сөрөг хүчин хийх гээд байгаа юм бол өнгөрсөн 2025 оны төсвийг мөлжихдөө Ардчилсан намын гишүүд яаж мөлжлөө. Өөрсдөдөө ашигтай байхаар юмыг яаж тал талаас нь судалж мөлждөг билээ. Яаж унагаах гэж мөлждөг билээ. Түүн шиг нь судлаад орж ирээд төрөл бүрийн асуудлуудыг тавиад, ингээд мэтгэлцээд ингээд энэ хуулийг унагааж болно шүү дээ.

Гэтэл зүгээр хаяад явж байгаа. Хаяад явахдаа яаж байна гэхээр манай Монголын ард түмэн мэдэж аваг. Энэ Улсын Их Хуралд ер энэ зарим гишүүд нь ямар сэтгэлтэй, ямар эрх ашигтай ажиллаад байгааг мэдэж авах хэрэгтэй.

Ирцдээ орсон юм чинь гарцгаая, гарцгаая гээд гарч байгаа юм. Ардчилсан намын дарга нь ингээд би бол гарлаа. Та нар эндээ үлдвэл өөрсдөө мэдээрэй гэж гишүүдээ дарамтлаад гарч байна гэдэг чинь энэ одоо юу гэсэн үг вэ?

Энэ хүмүүс хоорондоо улс төржиж болно.

Гэхдээ Монголын ард түмний тулгамдсан асуудал, Монгол төрийн ажил зогсолтгүй явж байх ёстой. Өнөө мөдгүй төрөх дөхчхөөд, одоо ингээд бэлцийтлээ хавагнаад энд сууж байгаа хүн ч гэсэн байна.

Яагаад энэ хуралд л суух гээгүй юм бол яах гэж энэ Улсын Их Хуралд өчнөөн үнэгний арьс нөмөрч, өчнөөн уран яруу донгодож, өчнөөн олон тэрбумыг зарлагдаж гарч ирдэг юм бэ энэ хүмүүс.

Одоо манай энэ баян Бажаа, С.Баярцогт тэргүүтэй Улсын Их Хурлын гишүүд өнгөрсөн жил яаж энэ төсвийг мөлжиж Монголын хүүхдүүдийн, нийт өсвөр насны хүүхдүүдийн 18.0 тэрбум төгрөгийг ямар их мөнгө гэж гасалж байсан хүмүүс энэ жил болохоороо 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай төсвийг ёстой боломжийн төсөв орж ирлээ шүү дээ гээд ингээд өхөөрдөөд сууж байна. Гайхаад байна.

Ямар үед нь 18.0 тэрбум төгрөг хүүхдүүдэд зарцуулахад асар их мөнгө болоод, ямар үед нь 1.3 их наядын алдагдал бүр өхөөрдөөд хайрламаар ийм дүн болчхоод байгаа юм бэ гэдгийг би бүр гайхаад байна.

Тэгэхээр Монголын ард түмэн мэдэж мэдэж аваг. Энэ дотор энэ улс орны төлөө, нийгмийн төлөө, үнэхээрийн иргэдийн төлөө гэсэн сэтгэлтэй маш цөөхөн хүмүүс байна. Тэр хүмүүс энд үнэхээр хүчин мөхөстөж байна.

Өнөөдөр сая Н.Номтойбаяр гишүүн яаж байгаа юм. Та энэ Хүнсний тухай хуульд үлдээд саналаа өгчхөөч гэсэн чинь би ямар, надад ямар хамаатай юм гээд гарч байх жишээний. Ингэж болдог юм уу? Ер нь.

Энэ өчнөөн олон парламентад суусан С.Одонтуяа гишүүн яаж байна. Сая. Ирцэндээ орсон юм чинь гарцгаая. Ийм Улсын Их Хурал гэж ер нь юу байх вэ? Ийм Улсын Их Хурлын гишүүд гэж юу байх вэ?

Энэ Монголчууд, Монголын иргэд, олон нийт, Монголын ард түмэн энэ Улсын Их Хуралд томилоод гаргасан байгаа энэ хэдэн хулгайч нараа ажлаа хийхийг шаардах хэрэгтэй байна.

Яахаараа ингэж гуйлгаад, гувшуулаад. Энэ чинь бүх нийтээрээ хэлэлцэх ёстой асуудал. Цаг нартай. Өнөөдрийн энэ хоёр асуудлыг хэлэлцээд маргаашийн дараагийн асуудлууд орж ирээд хэлэлцэх ёстой биз дээ.

Өнөөдөр гудамжинд ахмадууд сууж байна. Багш нар боловсролын жилд ажил хаялт зарлаж байна. Гэтэл ийм олон олон тулгамдсан асуудлууд байж байхад байнгын. Долоо хоногт хоёрхон удаа энэ чуулган чинь хуралдаж байгаа шүү дээ. Тэгэхэд одоо ингээд л байнгын чуулганаас завсарлага авна.

Асуудлаа судлаач. Нөгөө мөлждөг, нөгөө түүдэг, нөгөө сайхан судалдаг мундаг мундаг боловсролтой баян Бажаа нар нь хаачсан юм. Үнэхээр гайхамшигтай.

Монгол төрийн ажлыг бүр ингэж яваад бүр сурсан юм байна, гаршсан юм байна, амтшсан юм байна.

Х.Булгантуяа: М.Нарантуяа-Нара гишүүн үг хэллээ.

Энэ хууль бол бас их чухал хууль.

Өнөөдөр Монгол Улсын иргэдийн хувьд хүнсний аюулгүй байдал, дээрээс нь нэмээд хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого, төсөв санхүүгээр бид дэмжихээс гадна суурь бодлого нь цаанаасаа хууль эрх зүйн орчин нь бас зөв байх ёстой гэдгийг Монголын ард түмэн бүгдээрээ мэдэж байгаа.

Энэ хуулийг хэр өргөн хүрээтэй хэлэлцүүлэх вэ гэдэг нь уг нь ялангуяа энэ хуулийг дараа нь амжилттай хэрэгжүүлэхэд нэн чухал байсан.

Энэ бол улс төржих асуудал биш. Ард түмний хувьд нэн чухал асуудал дээр аль нэг нам, эвсэл уг нь бүгдээрээ л нийлээд л хамтдаа өргөн хүрээгээр хэлэлцүүлсэн бол үр дүн илүү сайтай байх байсан.

Тэгээд харамсалтай нь тэгж чадсангүй. Олон хүмүүс асуулт асууж, үг хэлэхээр байсан. Ирцдээ орчхоод чуулганы хуралдаандаа орж ирсэнгүй.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлье.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан байхгүй байна. Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа. 1 номерын индрээс.

Д.Ганмаа: Би цөөхөн хэдхэн үгийг хэлье гэж бодож байна.

Маш чухал хууль орж байгаа. Тэгээд харамсалтай нь улс төржилт, бөөн асуудлууд үүсээд энэ чухал хуульд анхаарч, анхаарал хандуулж, зайлшгүй байх ёстой энэ асуудлуудыг хэлэлцэж чадахгүй байгаад нэгдүгээрт тун харамсаж байгаагаа хэлье.

Яагаад тун харамсалтай санагдаж байгаа вэ гэхээр бид энэ чинь уг нь мэтгэлцээний талбар гэж бид нарт эхнээсээ оруулж ирсэн. Мэтгэлцээн гэж яг мэргэжлийн үүднээс бие биетэйгээ яриад, хэлэлцээд. Тэгснээрээ энэ хууль боловсролт нь сайжирч, үнэхээрийн амьдралд хэрэгтэй, дахин дахин засаж

залруулаад байхгүй, тэгээд шууд хэрэгжиж болохуйц ийм хуулиудыг бий болгох. Тэр нь ялангуяа эрдэм шинжилгээ, судалгаа, мэдээ мэдээлэл дээр заавал тулгуурласан байх ёстой. Тэгээд мэргэжлийн хүмүүс энд зайлшгүй оролцох ёстой. Энэ байр суурь маш хатуу байх ёстой.

Яагаад гэхээр яг энэ хууль дээр ярихад ядаж л эрүүл мэндийн хувьд жишээлбэл хүнсний аюулгүй байдал, хүнсний баталгаат байдал гэдэг тэс хоёр өөр ойлголтыг англиас буруу орчуулаад, түүнээсээ болоод хэчнээн жил буруу, болохгүй үр дагаврыг нь амсаж явав даа бид нар.

Хоёрдугаарт, яагаад маш чухал гэж яриад байгаагаа бас хэлье.

Жишээлбэл, бид нарын хийгдсэн Монгол Улсад тухайн яг нөхцөлд тааруулсан судалгаануудаар Д амин дэмээр баяжуулсан сүүг хүүхдэд 1 сар, 3 сар, 3 жил гэх мэтчилэн янз янзын хугацаанд хэрэглэхэд Д амин дэмээр баяжуулаагүй сүүтэй харьцуулахад SUPPLEMENT¹ хэрэглэсэн хүмүүстэй харьцуулахад ерөөсөө амьсгалын замын хурц халдвар өвчин 50 хувиар бууж, эмнэлгийн хэвтэлт буурч, хүүхдүүд, эх эцгүүд, сургуулийн амьдралын чанарт 100 хувиар нөлөөлж байсан нь батлагдсан, амьдрал дээр хэрэгжсэн. Энэ ажил.

Нэмээд эдгээр хүүхдүүдийн өсөлт өндөр, хөгжил яг бусад хөгжингүй орны хүүхдүүдийн өндөр, өсөлт, биеийн хөгжилтэй эн зэрэгцэж ирсэн. Маш богино хугацаанд зөв интервенцийг яг хэрэгжүүлээд явахад бид амьсгалын замын хурц халдварт өвчин, бусад өвчлөлүүдийг бууруулах бүрэн боломж байгаа.

Харьцангуй бага мөнгөөр. Энэ дээр мэргэжлийн хүмүүсийгээ сонсож, мэргэжлийн үйл ажиллагаа явуулж баймаар байна.

Яг үүнтэй холбоотой, сая гараад явсан Ардчилсан намын бүлэгт хүүхэд эрүүл мэнд шим тэжээлээр. Би энэ тухай бүр мэдээ, мэдээлэл хийж явмаар байна. Үүнийг хүлээж авна уу гэж хүсмээр байна.

Гуравдугаарт, бид нарын яримаар байгаа зүйл. Ер нь асуудлыг маш өргөн хүрээнд буюу хүнсний систем байдлаар авч үзэх зайлшгүй шаардлагатай.

Юу гэсэн үг вэ гэхээр зэрэг бид нөлөөллийн ажил, мэдээллийн ажлууд. Эдгээрийг маш сайн хийхгүй бол зүгээр үл ойлголцлоос болж маш олон асуудал удаж саатаж, саарч, хэн нэгнийх нь ширээн дээр хэвтсээр байгаад хэчнээн жил хугацаа алддаг.

Яг ийм асуудлууд жишээлбэл хүнсний баяжуулалтын хууль дээр ч гэсэн гарсан. Эрүүл мэндийн салбарынхныг ч, хүнсний технологийнхныг ч эдгээрийг зайлшгүй хамтарсан байдлаар үүнийг уялдаа холбоотой явуулах нь зайлшгүй

¹ Витамин, эрдэс бодис, уураг, амин хүчил гэх мэт биед хэрэгтэй бодисыг нэмэлтээр авах зорилготой капсул, нунтаг, шингэн, шахмал хэлбэртэй бүтээгдэхүүн.

шаардлагатай. Яагаад гэвэл энэ маш хүлээлттэй, маш том өөрчлөлтийг авчрах болхуйц ийм хууль.

Энэ дээр яг мэргэжлийн салбарын хүмүүс, шинжлэх ухаан, технологийн сургуулийн эрдэмтэн, докторууд энэ NUTRITION² дээр ажилладаг их чадвартай багтай юм билээ. Би Харвардад байхдаа анх хамтарсан судалгааны ажлыг... /минут дуусав/

Х.Булгантуяа: Д.Ганмаа гишүүн эрдэмтэн, доктор хүний хувьд чухал саналыг хэллээ.

Энэ хууль нэн чухал хууль байгаа. Хууль санаачлагчийн зүгээс нэр томъёог нь сайжруулах, дээрээс нь нэмээд хуулийн давхардлыг сайжруулах, өмнөх хуульд хуульд тусгагдаагүй байсан зарим зохицуулалтуудыг тодруулж нэмж тусгах, илүү ил тод, хариуцлагатай, эрсдэлийн удирдлагад суурилсан тогтолцоог бий болгох зорилготойгоор хуулийн төслийг боловсруулж өргөн барьсан байна.

Гэхдээ хэрэгжилтийн түвшинд ялангуяа гарал үүслийн мөшгөлт, ЖДҮ-гийн чадавх, шинэ агентлагийн бүтэц, нэмэлт зардал бэлтгэл шаардагдана.

Тэгэхээр үүн дээр Та бүхэн ажлын хэсгийн хүрээнд нэмж ажиллана. Сайжруулах хэрэгцээ шаардлага байгаа байх гэж бодож байна.

Тэгээд Улсын Их Хурлын гишүүд ээ,

Өнөөдөр энэ Хүнсний тухай хууль дээр нийтдээ 2 цагийн хуулийн хэлэлцүүлэг явахаар Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгч, бараг 20 гаруй гишүүд асуулт асууж, үг хэлэхээр байсан.

Тэгээд харамсалтай нь улс төрийн нөхцөл байдлаас гээд нэг хэсэг нь чуулганаа хаяад гарснаас үүдээд хэлэлцүүлэг маань өргөн хүрээнд явагдаж чадсангүй. Санал хураалт дээр ч гэсэн гишүүдийн ирц харьцангуй бага байна.

Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.12-ын дагуу санал хураалтыг дараагийн чуулганаар нэгтгэн явуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингээд өнөөдөр энэ хуулийг дагаж 10 гаруй хуулийн төслүүдийг хэлэлцэхээр байсан. Санал хураалтуудыг хойшлуулаад дараагийн чуулганаар явуулъя.

² Хүний бие махбодод шаардлагатай шим тэжээлийг (уураг, өөх тос, нүүрс ус, витамин, эрдэс бодис гэх мэт) хоол хүнсээр дамжуулан авах, боловсруулах, шингээх үйл явцыг хэлнэ.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 06 минут үргэлжилж, 11 цаг 06 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД